

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР
САРЫН 10-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-7
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	8-69
	1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-22
	2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	22-45
	3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	45-56
	4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-59
	5.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	59-64
	6.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-67
	7.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	67-68
	8.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	68-69

ХУРАЛДААНЫ ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч С.Орхон, Б.Гэрэлсайхан, ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр хариулж, тайлбар хийв.

П.Анужин: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын ЗГ-аас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хэлэлцье.

Хуулийн төслийн танилцуулгыг ХНХ-ын сайд Төмөрбаатарын Аюурсайхан хийнэ.

Т.Аюурсайхан: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн харилцааг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай болон нийгмийн даатгалын сангаас олгох Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Дээрх хуулиудыг мөрдөж эхэлснээс хойш нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах эрх, нөхцөл тэтгэмж бодох хувь хэмжээг өөрчлөх зэрэг хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Тухайлбал, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулсан хэлбэрээс үл хамааран адил хувь хэмжээгээр тооцох, хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхийн зөвхөн 2 удаагийн төрөлтөд тэтгэмж олгож байсныг төрөлт болгон тэтгэмж олгохоор, ажлаас халагдсан шалтгаанаас хамаарахгүйгээр ажилгүйдлийн тэтгэмжийг олгохоор, хүндэтгэх шалтгаантай тэтгэмж авах өргөдлийг 3-6 сарын дотор гаргах зэрэг даатгуулагчийн эрх ашигт нийцсэн хуулийн зохицуулалтыг тусгаж байсан.

Тэтгэмжтэй холбоотой тулгамдсан асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тухай бүр шийдвэрлэсэн боловч нийгмийн даатгалын сангийн тогтвортой бие даасан байдлыг түр хугацаанд хангах, тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгож буй тэтгэмжийн хэмжээ, хугацааг өөрчлөх, нөхцөл, шалгуурыг даатгуулагчид ээлтэй байдлаар уян хатан болгох зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлага байсаар байна.

Мөн одоогоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжийн харилцааг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар, ажилгүйдлийн тэтгэмжийн харилцааг нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Эдгээр богино хугацааны тэтгэмжийн харилцааг 2 өөр хуулиар мөн даатгуулагчийн урт хугацааны тэтгэврийн харилцааг тэтгэмжийн харилцаатай нэгтгэн нэг хуулиар зохицуулж байгаа нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид ойлгомжгүй байдлыг үүсгэж ирсэн.

Иймд тэтгэмжийн даатгалын харилцааг нэг хуулиар зохицуулахаар нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөл боловсруулсан.

Хуулийн төсөлд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгохоор харин ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан.

Мөн бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар ажлын 66 хоног байсныг 132 өдрөөс хэтрэхгүй байхаар нэмэгдүүлсэн.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний тухай 1952 оны 102 дугаар конвенцод иргэнд олгох тэтгэмжийн доод хэмжээ нь түүний авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй

адилтгах орлогын 50 хувиас багагүй байхаар заасан конвенцын шаардлага зөвлөмжид нийцүүлэн ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийг хувийг нэмэгдүүлсэн.

Даатгуулагчийг ажилгүй болгохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор суурьшилтай урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагч авах тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж, даатгуулах хүсэл сонирхол нэмэгдэж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангахад эерэг нөлөө үзүүлэх, хуулиудын уялдаа холбоо сайжирч, иргэд даатгуулагч, ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллага хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон төрийн байгууллага даатгуулагчид нэмэлт зардал үүсэхгүй. Харин нийгмийн даатгалын сангаас 744.8 сая төгрөгийг даатгуулагч болон ажил олгогчийн тэтгэмж, хөнгөлөлтөд нэмж олгох урьдчилсан тооцоо гарч байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хуулийн төслийг хэлэлцэж хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Аюурсайхан сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Цэвэгдоржийн Туваан гишүүнээр таслаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Үгүй ээ, би ганцханыг гэсэн шүү дээ. Танаас зөвшөөрөл ганц. Энэ зөв зөв. Ер нь бас энд тэндээ ингээд юу баахан ингээд эрээвэр хураавар үхрийн бөөр шиг яваад байдаг юм ингээд нэг цэгцэлчихсэн нь зөв байх. Тэгээд энэ дээр бас нэг яг одоо энэ авч байгаа тэтгэмжийн хэмжээ ер нь яг хэд байна. Тэгээд та хэд энэ тэтгэмжийн энэ хууль нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль батлагдсанаар хэдэн төгрөг болно гэж харж байгаа юм бэ? Нэмэгдэнэ гээд сая энэ сайдын танилцуулгад ороод ингээд явчихлаа. Тэгэхээр үүний хэмжээг нэг хэлээдхээч.

Дараагаар нь энэ хүмүүс энэ НДШ төлөлт дээрээ бас нэг ойлгодоггүй, мэддэггүй нэг асуудал байдаг. Тэр нь юу вэ гэхээр шимтгэл төлсөн хүн эргээд энэ саяын энэ нийгмийн даатгалын сангаас авах энэ тэтгэмжүүдийн эрх нээгддэг гэдэг талаар ойлголтгүй байгаад байдаг. Энэ дээр бас түүнийг урамшуулах ч байдаг юм уу, сурталчлах ч байдаг юм уу. Энэ талаар бас хуульд орсон зүйл байна уу гэдэг асуулт асууя.

П.Анужин: 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулт өгье.

Г.Өнөрбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Бид нар та бас сая хэллээ. Тэтгэмжийн харилцааг олон өөр зохицуулалтуудаар зохицуулаад байсныг

багцлаад нэг болгож оруулж ирээд явж байгаа. Энэ нь иргэдэд ойлгомжтой тодорхой болгох ийм чухал шинэчлэлийг оруулж ирж байгаа.

Тэтгэмжийн хууль дээр бас хэд хэдэн чухал зохицуулалтуудыг оруулж ирж байгаа. Ажилгүйдлийн тэтгэмж өмнө нь цалингийн 45 хувийн суурьтай байсан бол 50 болгоод ингээд бас нэмэгдүүлээд пропорцоор нь бас оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Мөн энэ ажил олгогч нарт бас тийм таатай нэмэгдлүүдийг бид нар бас оруулж ирж байгаа. Өмнө нь одоогийн байгаа хуулиар энэ нийгмийн даатгалын сангаас ингээд ажилгүйдлийн тэтгэмж гаргаагүй ийм ажил олгогчдыг урамшуулахдаа 5 жилд 10 хувь хувиар урамшуулдаг байсныг одоо бид нар 3 жилд 15 хувиар урамшуулдаг болгож энэ ААН-үүдийг бас ийм дэмжиж байгаа зохицуулалтуудыг бас оруулж ирсэн гэдгийг хэлье.

Мөн энэ донор болон донор болж байгаа тохиолдолд 2 зүйлийг бид нар бас энэ тэтгэмжийн хууль дээр шинээр нэмж оруулж ирсэн. Донор болсон тохиолдолд өөрөөр хэлбэл шинээр оруулж ирээд хугацааг нь бид нар бас нэмэгдүүлж оруулж ирсэн. Өмнө нь энэ 66 хоногоор авдаг байсныг бид нар 132 хоногоор бас акт авдаг болгож оруулж ирсэн гэдгийг бас хэлье.

Дээр нь нэмээд та бас их чухал зүйлийг хөндөөд байна. Ялангуяа энэ тэтгэмжтэй холбоотойгоос гадна энэ нийгмийн даатгалын харилцаануудтай холбоотой хүмүүст ойлгуулах, буруу зөрүү ойлголттой байх мэдээлэлгүйгээсээ болох ийм тохиолдлууд бас их байдаг учраас бид нар энэ хуулийн шинэчлэлийн нэг том зорилт ялангуяа нийгмийн даатгалын харилцааг олон нийтэд ойлгуулах, даатгуулагч болгонтой бас тулж ажиллах мэдээлэл өгөх, урьдчилан соён гэгээрүүлэх энэ чиглэлийн харилцаануудыг бас хуулийн төсөлд нэлээн тодорхой оруулж ирсэн гэдгийг хэлье. Анхаарлаа тавьсанд баярлалаа.

П.Анужин: Баярлалаа. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг хэлэх гишүүн алга байна.

Монгол Улсын ЗГ-аас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

60 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр УИХ-ын гишүүн Цэвэгдоржийн Тувааныг томилж байна.